



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 7/2020

Номгон

“Монголын Уламжлалт анагаах ухааны
ололт, амжилт, шийдэл” хуралд оролцоход
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд зохион байгуулагдсан “Уламжлалт анагаах ухааны ололт, амжилт, шийдэл” хуралд орон нутгийн өвөрмөц онцлог, өв соёлыг сурталчлан таниулах зорилгоор оролцсон албан хаагчдын бэлтгэсэн идээ ундаа, хувцас эд хэрэглэлийн зардалд хөрөнгө зарцуулсугай.

2. Уламжлалт идээ ундаа, хувцас эд хэрэглэлийн зардал 1,000,000 (Нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Монголын уламжлалт анагаах ухааны идээ ундаа, явдал мөр, эрүүл амьдралын дадал хэвшлийг түгээн дэлгэрүүлэхийг Эрүүл мэндийн газар (Г.Лхагва-Очир)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

